

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2014 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Засгийн газарт чиглэл өгөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.4, 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэгт заасныг үндэслэн Өргөдлийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Улсын зарим хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т чиглэл болгосугай:

1.1. Газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах тухай аймгийн нутгийн удирдах байгууллагуудын хуульд нийцээгүй 1738 шийдвэрийг хуульд нийцүүлэх арга хэмжээг авах, энэ хугацаанд тухайн шийдвэрүүдэд дурдсан газруудад ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгохыг түдгэлзүүлэх;

1.2. Газрыг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авах тухай шийдвэр гаргахад газрын байршил, хил, заагийг зөв тогтоох, хамгаалалтын шаардлага хангахуйц хэмжээтэй байх талаар мэргэжлийн аргачлал, зөвлөмжөөр хангах;

1.3. Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд улсын хэмжээнд хяналт шалгалтыг хийж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авах;

1.4. Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороонд ирсэн иргэдийн өргөдлийн дагуу хийсэн хяналт шалгалтын дүнг үндэслэн дараах арга хэмжээг авах:

1.4.1. Дорноговь аймгийн Айраг сумын нутагт байрлах Цагаан дэлийн агуйг орон нутгийн болон улсын тусгай хамгаалалтад авах, байгаль орчинд учирсан хохирлыг тооцож, буруутай этгээдээр нөхөн төлүүлэх арга хэмжээ авах, уул, уурхайн ашиглалтын үйл ажиллагаанаас хохирсон иргэдэд нөхөн төлбөр олгох, эрх ашгийг хамгаалах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх;

1.4.2. Дэлгэрэх сумын нутагт байрлах Чандмань хар уулын тусгай хамгаалалтад авсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх, тус суманд хууль зөрчин явуулж буй бичил уурхайн үйл ажиллагааг зогсоох, буруутай этгээдүүдэд хариуцлага тооцох;

1.4.3. Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Хутаг уулыг орчны байгаль, түүх, соёлын дурсгалт газруудын хамт улсын тусгай хамгаалалтад авах;

1.4.4. Дорноговь аймгийн Хөвсгөл сумын нутагт байрлах Хутаг уул, Баянхонгор

аймгийн Баян-Өндөр сумын нутагт байрлах Аман гол нэртэй газарт Ашигт малтмалын тухай хуулийн **401 дүгээр зүйлийн** 401.2 дахь хэсэгт заасныг зөрчин явуулж буй ашигт малтмал хайх, ашиглах үйл ажиллагааг зогсоон хяналт шалгалт хийж, зохих журмын дагуу шийдвэрлэх;

2.Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.23, 12 дугаар зүйлийн 12.1.5, Засгийн газрын 2010 оны 308 дугаар тогтоолоор баталсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг ноцтой зөрчсөн Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 09 сарын 24-ны өдрийн 6/02 дугаар тогтоолыг хүчингүй болгож, зөрчлийг арилгах арга хэмжээ авахыг Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд чиглэл болгосугай.

3.Тогтоолын биелэлтийг 2015 оны хаврын чуулганы хугацаанд багтаан зохион байгуулж, тус Байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т даалгасугай.

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.БУРМАА